найдвар

Есүс цэх зогсож, тэр эмэгтэйд —Эмэгтэй, тэд хаана байна? Чамайг хэн ч шийтгэсэнгүй юу? гэсэнд тэр —Эзэн, хэн ч шийтгэсэнгүй гэв. Есүс —Би ч чамайг шийтгэхгүй. Яв. Үүнээс хойш дахин нүгэл бүү үйлд гэлээ. ИОХАН 8:10-11

Харин тэд зогсоо зайгүй асуусанд Есүс цэх зогсоод, тэдэнд—Та нарын дундаас нүгэлгүй нь эхлээд энэ эмэгтэй уруу чулуу шид гээд, ИОХАН 8:7

Би зөвтийг бус, харин нүгэлтнүүдийг гэмшилд дуудахаар ирсэн юм гэв. ЛУК 5:32

БИДНИЙ БҮРЭН ОЙЛГОХ ЁСТОЙ ДӨРВӨН ҮНЭН БАЙДАГ:

1 БУРХАН ЧАМД ХАЙРТАЙ.

БУРХАН ЧАМАЙГ ТҮҮНТЭЙ ХАМТ ТЭНГЭРТ МӨНХ АМЬТАЙ БАЙГААСАЙ ГЭЖ ХҮСДЭГ.
Бурхан ертөнцийг үнэхээр хайрласандаа цорын ганц Хүүгээ өгсөн тул Хүүд итгэдэг бүхэн мөхөхгүй харин мөнх амьтай байх болно. ИОХАН 3:16
БУРХАН ЧАМАЙГ УТГА УЧИРТАЙ АМЬДРАЛТАЙ БАЙГААСАЙ ГЭЖ ХҮСДЭГ.
Хулгайч зөвхөн хулгайлан, алж, сүйтгэхээр ирдэг. Би тэднийг амьтай, бялхсан амьтай байлгахын тулд ирсэн билээ. ИОХАН 10:10

2 ХҮН УГААСАА НҮГЭЛТЭЙ. ТИЙМЭЭС ТЭР БУРХАНААС ТУСГААРЛАГДСАН.

Бүгд нүгэл үйлдсэн тул Бурханы алдар сууд хүрдэггүй авч; РОМ 3 3:23

Учир нь нүглийн хөлс нь үхэл... РОМ 6:23

- **БИЕ МАХБОДИЙН ҮХЭЛ**

Хүн ганц удаа үхэж, дараа нь шүүгдэхээр товлогдсон шиг: ЕВРЕЙ 9:27

- **СҮНСЛЭГ ҮХЭЛ**

Харин хулчгар, итгэлгүй, жигшүүрт, алуурчид, завхайрагчид, мэргэчид, шүтээнд мөргөгчид болон бүх худалчуудад ногдох хувь нь хоёр дахь үхэл буюу хүхэр, галаар шатаж буй нуур юм гэв. ИЛЧЛЭЛ 21:8

ХЭРЭВ ХҮН НҮГЛИЙНХЭЭ УЛМААС БУРХАНААС ТУСГААРЛАГДВАЛ ЭНЭ АСУУДЛЫГ ШИЙДЭХ АРГА ЮУ ВЭ? БИД ЭДГЭЭРИЙГ ИХЭВЧЛЭН ШИЙДЭЛ ГЭЖ БОДДОГ: ШАШИН, САЙН ҮЙЛС, ЁС СУРТАХУУН ГЭСЭН ХЭДИЙ Ч БУРХАНЫ ӨГСӨН ЦОРЫН ГАНЦ ШИЙДЭЛ БАЙДАГ.

3 ЕСҮС ХРИСТ БОЛ ДИВААЖИНД ХҮРЭХ ЦОРЫН ГАНЦ ЗАМ ЮМ.

Есүс түүнд: Би бол зам, үнэн, амь мөн. Надаар дамжихгүй бол хэн ч Эцэгт ирэхгүй. ИОХАН 14:6

Учир нь Христ ч нэг удаа нүглийн төлөөнөөс үхэж, биднийг Бурханд аваачихын тулд зөвт нь зөвт бусыг орлосон. Ингэхдээ махбодод үхэж, сүнсэнд амилуулагдав. 1ПЕТР 3:18

Хүүд итгэдэг нь мөнх амьтай. Харин Хүүд дуулгаваргүй нь мөнх амийг эс үзэх бөгөөд Бурханы уур хилэн түүн дээр оршино. ИОХАН 3:36

4 БИД АВРАЛЫНХАА ТӨЛӨӨ ИХ ЭЗЭН ЕСҮС ХРИСТЭД ИТГЭХ ЁСТОЙ.

ЕСҮС ХРИСТЭД ИТГЭХ ИТГЭЛЭЭР ДАМЖУУЛАН БУРХАНЫ НИГҮҮЛСЛЭЭР БИДНИЙ АВРАЛ БОЛОМЖТОЙ БОЛСОН. Нигүүлслийн учир итгэлээрээ аврагдсан нь та нараас бус харин Бурханы бэлэг бөгөөд. үйлсээр чинь биш тул хэн ч үл сайрхах болно. ЕФЕС 2:8-9

ЭНЭ ЗАЛБИРЛЫГ БУРХАНД ИТГЭЛЭЭР ХЭЛ:
ЭЗЭН ЕСҮС, НАМАЙГ ГЭСЭН АГУУ ХАЙРАНД ТАНЬ МАШ ИХ БАЯРЛАЛАА. БИ ГЭМ НҮГЛЭЭ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРЧ, УУЧЛАЛТ ГУЙЖ БАЙНА. МИНИЙ ГЭМИЙН ШИЙТГЭЛИЙГ ТӨЛӨХИЙН ТУЛД ЗАГАЛМАЙ ДЭЭР ҮХСЭНД БАЯРЛАЛАА. БИ ЧИНИЙ ҮХЭГСДЭЭС АМИЛСАН ГЭДЭГТ ИТГЭДЭГ. ОДООНООС ЭХЛЭН БИ ЧАМД ӨӨРИЙН АВРАГЧ, ЭЗЭН ГЭДЭГТ ИТГЭЖ БАЙНА. БИ ЧИНИЙ МӨНХ АМЬДРАЛЫН БЭЛГИЙГ ХҮЛЭЭН АВЧ, АМЬДРАЛАА ЧАМД ДААТГАЖ БАЙНА. ТАНЫ ЗАРЛИГУУДЫГ ДАГАЖ, ТАНД ТААЛАГДАХАД НАДАД ТУСЛААЧ. АМЕН.

ХЭРЭВ ТА ЕСҮС ХРИСТЭД ИТГЭДЭГ БОЛ ТАНД ДАРААХ ЗҮЙЛ ТОХИОЛДСОН.

- **ТА БУРХАНТЭЙ МӨНХ АМЬДРАЛТАЙ.**

Хүүг харж, Түүнд итгэгч бүр мөнх амьтай байх нь Эцэгийн минь хүсэл юм. Эцсийн өдөрт Би түүнийг амилуулна гэж айлдлаа. ИОХАН 6:40

- **ТАНЫ БҮХ НҮГЭЛ УУЧЛАГДСАН.**

(ӨНГӨРСӨН, ОДОО, ИРЭЭДҮЙ) Тэр биднийг харанхуйн эрх мэдлээс авраад, хайрт Хүүгийнхээ хаанчлалд шилжүүлсэн юм. Хүүгийнх нь дотор бидэнд нүглийн уучлал болох золилт байна. КОЛОССАЙ 1:13-14

- **ТА БОЛ БУРХАНЫ ӨМНӨ ЦОО ШИНЭ АМЬТАН ЮМ.**

ЭНЭ БОЛ ТАНЫ ШИНЭ АМЬДРАЛЫН ЭХЛЭЛ ЮМ.

Тиймээс хэн нэг нь Христ дотор байвал тэрээр шинэ бүтээл мөн. Харагтун, хуучин нь өнгөрч, шинэ болсон байна! 2КОРИНТ 5:17

- **ТА ОДОО БУРХАНЫ ХҮҮХЭД БОЛСОН.**

Харин Өөрийг нь хүлээн авсан болгонд, Өөрийнх нь нэрэнд итгэгчдэд Тэрээр Бурханы хүүхэд болох эрхийг өглөө. ИОХАН 1:12